



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/164

Улаанбаатар хот

Харуулыг татан буулгах, цаг уурын өртөөг
харуул болгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Завхан аймгийн "Яруу-Яруу", Баянхонгор аймгийн "Шар-Ус-Гурванбулаг", Ховд аймгийн "Улаан-Ам-Эрдэнэбүрэн", Төв аймгийн "Шивэрт-Борнуур", Булган аймгийн "Хангал-Жаргалан", Хэнтий аймгийн "Улз-Норовлин", Дорнод аймгийн "Нөмрөг-Хилийн застав", Увс аймгийн "Хангилцаг-Цагаанхайрхан", "Хяргас-Хартэрмэс" ус судлалын харуул, Увс аймгийн Бөхмөрөн сумын "Бөхмөрөн" хөдөө аж ахуйн цаг уурын харуулыг тус тус татан буулгасугай.

2.Увс аймгийн Наранбулаг сумын "Наранбулаг", Ховд сумын "Хөхтолгой", Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын "Хөхнуур" цаг уурын өртөөг 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хөдөө аж ахуйн цаг уурын харуул болгосугай.

3.Хөдөө аж ахуйн цаг уурын "Наранбулаг" харуулын индексийг "44831", "Хөхтолгой" харуулын индексийг "44838", "Хөхнуур" харуулын индексийг "44546" гэж тус тус тогтоосугай.

4.Татан буулгасан ус судлалын болон хөдөө аж ахуйн цаг уурын харуулын тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хүлээн авахыг ажлыг зохион байгуулахыг холбогдох аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт даалгасугай.

5.Энэхүү тушаалын хэрэгжилт болон үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Технологи, инновацийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Батболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

151250485